

БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“Булган АЗЗА” ТӨХК-ий 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: БУА-2025/003/НА-СТА-ТӨҮГ

Цахим хуудас: www.audit.mn

Булган аймаг

2023 он

Булган аймаг дахь Төрийн аудитын, дарга,
тэргүүлэх аудиторын албан тушаалын үүргийг түр орлон
гүйцэтгэгч: Ж.Энхцоодол

Утас: 70342580

Ахлах аудитор:

Утас: 70342716

Цахим хаяг: Enkhtsoodolj@audit.gov.mn

Г.Намчинсүрэн

Цахим хаяг: Namchinsureng@audit.gov.mn

Нэг.Аудитын санал дүгнэлт



БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант, 5-р баг, Булган сум, Булган аймаг,
63082, Утас/Факс: 7034-2580
Цахим шуудан: bulgan@audit.gov.mn

2025.03.13 № 327
танай _____ ны № _____ т

БУЛГАН АЗЗА ТӨХК-ИЙ
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
М.НУВААНТАЯ ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу “БУЛГАН АЗЗА” ТӨХК-ий 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Тайлант онд Зам тээврийн яамтай байгуулсан гэрээнд заасан заалтын дагуу 142,449.8 мянган төгрөгийн ажлыг туслан гүйцэтгэгчээр гүйцэтгүүлэхдээ зам тээврийн яамнаас зөвшөөрөл авч гүйцэтгүүлээгүй, албан хаагчдад илүү цагаар ажилласны нэмэгдлийг тооцон олгохдоо анхан шатны баримтгүй 372.2, ажилчдад олгохоор тооцсон цалингаас 331.4 мянган төгрөгийг илүү тооцон олгосон, албан хаагчдад анхан шатны баримтгүй томилолтын зардалд 1,370.0, ахмадын баяр, замчдын баяр тэмдэглэн өнгөрүүлэх зардалд 3,736.8, сургалтын зардалд 2,902.0 мянган төгрөгийг шатны баримтгүй зарцуулсан, албан хаагчдыг шагнаж урамшуулахдаа байгууллагын дотоод журамд заасан мөнгөн дүнгээс илүү 2,100.0 мянган төгрөгийн шагналыг илүү олгосон, Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчин 1,000.0 мянган төгрөгийн хандивт зарцуулсан зэрэг зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 25.10, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12.14, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1, 13.7, 20.1.1, 20.1.2, 20.1.4, 20.2.4 заалтууд болон санхүүгийн тайлангийн аудитын үнэлгээ ба хуваарилалт, тохиолдсон байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй ба бидний тогтоосон

632500642

материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Компанийн удирдлага болон ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг 9 хүнтэй ажиллаж байсныг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2024 оны 04 сарын 18-ны өдрийн 153 тоот тогтоолоор татан буулгаж, Засгийн газрын 2023 оны 220 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2024 оны 03 сарын 21-ний өдрийн 108 дугаар тогтоолоор төрийн өмчийн авто зам засвар арчлалтын 20 компанийг “Авто замын засвар арчлалтын нэгтгэл” ТӨХК-ийн охин компанийн хэлбэрт үе шаттайгаар шилжүүлэх ажил хийгдэж байна

Аудитын гол асуудал

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2023 оны 12 дугаар сарын 26 -ний өдрийн 777 тоот тогтоолоор 2024 оны оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна.

Тайлант оны нийт орлогыг 2,156.3 сая төгрөгөөр, нийт зардлыг 2,139.0 сая төгрөгөөр, 17.4 сая төгрөгийн ашигтай ажиллахаар тогтоосон ба 1,507.6 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 2,249.4 сая төгрөгийн зардал гарган, 741.8 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Бусад асуудал

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН АЛБАН ТУШААЛЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ  ЖЭНХЦООДОЛ

Хоёр. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

Үзүүлэлтийн нэр	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1.ХӨРӨНГӨ	1,887,341.28	1,626,948.82
1.1.Эргэлтийн хөрөнгө	744,160.68	417,669.98
1.1.1.Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	2,323.91	4,899.83
1.1.2. Дансны авлага	362,184.07	191,152.37
1.1.3. Бусад авлага	66.01	175.47
1.1.4.Бара материал	379,586.69	221,442.31
1.1.11. Эргэлтийн хөрөнгийн дүн	744,160.68	417,669.98
1.2. Эргэлтийн бус хөрөнгө	1,143,180.61	1,209,278.84
1.2.1 Үндсэн хөрөнгө	840,060.61	903,158.84
1.2.2 Биет бус хөрөнгө	303,120.00	306,120.00
1.2.12 Эргэлтийн бус хөрөнгийн дүн	1,143,180.61	1,209,278.84
1.3 НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	1,887,341.28	1,626,948.82
2.1 Өр төлбөр	1,011,550.36	1,307,235.59
2.1.1 Богино хугацаат өр төлбөр	446,339.05	742,024.28
2.1.1.1 Дансны өглөг	284,860.57	449,312.60
2.1.1.2 Цалингийн өглөг	16.13	0
2.1.1.3 Татварын өр	115,209.56	194,518.54
2.1.1.4 НДШ-ийн өр	46,252.79	98,193.14
2.1.1.13 Богино хугацаат өр төлбөрийн дүн	446,339.05	742,024.28
2.1.2.4 Бусад урт хугацаат өр төлбөр	565,211.31	565,211.31
2.1.2.6 Урт хугацаат өр төлбөрийн дүн	565,211.31	565,211.31
2.2 Өр төлбөрийн нийт дүн	1,011,550.36	1,307,235.59
2.3 Эздийн өмч	1,098,247.18	1,098,247.18
2.3.1 Төрийн	1,098,247.18	1,098,247.18
2.3.6 Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	752,128.12	964,858.12
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	752,128.12	964,858.12
2.3.9 Хуримтлагдсан ашиг	-974,584.38	-1,743,392.08
Өмнөх	-974,584.38	-1,001,591.71
Тайлант үе	-0.00001	-741,800.37
2.3.11 Эздийн өмчийн дүн	875,790.93	319,713.23
2.4 ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	1,887,341.28	1,626,948.82

Гурав. Байгууллага, түүний үйл ажиллагаа

“Булган АЗЗА” ТӨХК нь “Олон улсын болон улсын чанартай хатуу хучилттай авто зам, төмөр бетон гүүр хоолойн засвар арчлалтын ажлыг хариуцан авто замын хөдөлгөөний аюулгүй байдлыг байнга ханган ажиллахыг эрхэмлэх” гэсэн зорилтын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

Компанийн дүрэмд зааснаар тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг авто зам, зам байгууламжийг барих, засварлах гэж тодорхойлсон, улсын бүртгэлийн гэрчилгээнд “хувьцаат компани” гэж бүртгэсэн бөгөөд өмчийн 100 хувийг төр эзэмшдэг төрийн өмчит хувьцаат компани юм.

“Булган АЗЗА” ТӨХК нь 204.1 км асфальт бетон хучилттай зам, 38.76 км хайрган хучилттай зам, 145.64 км ердийн болон сайжруулсан хөрсөн зам бүгд 388,5км Олон улсын болон улсын чанартай замын бэлэн байдлыг хариуцсан ажилладаг.

Үүнд: А0901 дугаартай Булган-Дашинчилэн чиглэлийн 71.5 м, А0902 дугаартай Булган-Мөрөн чиглэлийн 158 км, А1002 дугаартай Эрдэнэт-Булган чиглэлийн 24.1 км, А13 дугаартай Хутаг-Өндөр-Тэшиг-Улсын хил чиглэлийн 134.9 км зам хариуцдагаас гадна Эгийн гүүр, Гуртын гүүр, Орхоны гүүр, орон нутгийн чанартай Хялганатын болон Хануйн гүүрүүд багтдаг.

2024 онд 33 орон тоотой, үйлдвэрлэл явуулах 15 тээврийн хэрэгсэл, 21 механизм, 27 техник тоног төхөөрөмжтэй Зам засварлах, барих нөхцөлийг бүрдүүлэн ЗТХЯ-тай байгуулсан гэрээний дагуу хариуцсан Олон улсын болон улсын чиглэлийн замын засвар арчлалтын ажлыг хийж гүйцэтгэхийн зэрэгцээ асфальт заводын үйлдвэрлэл явуулж нийт 343.6 тонн асфальт зуурмаг үйлдвэрлэж өөрийн хариуцсан чиглэлийн замуудын нөхөөс болон гүүрний суултад ашиглаж, иргэн аж ахуй нэгж байгууллагуудад зарж борлуулсан байна.

Компанийн удирдлага болон ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг 9 хүнтэй ажиллаж байсныг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2024 оны 04 сарын 18-ны өдрийн 153 тоот тогтоолоор татан буулгаж, Засгийн газрын 2023 оны 220 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2024 оны 03 сарын 21-ний өдрийн 108 дугаар тогтоолоор төрийн өмчийн авто зам засвар арчлалтын 20 компанийг "Авто замын засвар арчлалтын нэгтгэл" ТӨХК-ийн охин компанийн хэлбэрт үе шаттайгаар шилжүүлэн ажиллаж байна.

Дөрөв. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Илүү цагийн хөлсийг үндсэн цалингийн дүнгээс бус хийж гүйцэтгэсэн ажлын зэрэглэлээр тооцон олгож байгааг харьяалах дээд байгууллагад уламжлан илүү цагийг тооцоолон олгох аргачлалыг холбогдох хуул дүрэм журамд нийцүүлэн тодорхойлох арга хэмжээг зохион байгуулах шаардлагатай байна.

2.МУ-ийн засгийн газрын 2029 оны 09 сарын 16-ны өдрийн 284 тоот тогтоолын дагуу дэлхийн банк болон Азийн хөгжлийн банкны урт хугацаат зээлээр санхүүжигдсэн хөрөнгийг дүрмийн санд бүртгээгүй байгааг харьяалах дээд байгууллагад уламжлан санхүүгийн бүртгэлд бүртгэх арга хэмжээг зохион байгуулах шаардлагатай байна.

Тав.Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 3.3 сая төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад алдааг залруулж ажиллаа.

Аудитаар нийт 171.9 сая төгрөгийн зөрчил² илэрснээс, 11.8 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 160.2 сая төгрөгийн 2 зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт

1. Албан хаагчдад илүү цагаар ажилласны нэмэгдлийг тооцон олгохдоо анхан шатны баримтгүй 372.2, ажилчдад олгохоор тооцсон цалингаас 331.4 мянган төгрөгийг тус тус илүү тооцон олгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1, 13.7, 20.1.2, 20.2.4 дэх заалт, санхүүгийн тайлангийн аудитын үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт хүргүүлсэн.

2. "Төв" АЗЗА, "Эрдэнэт сан " АЗЗА ТӨХК-ийн ойн арга хэмжээнд хандив олгоосон нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12.14, Төсвийн тухай хуулийн 25.10-

¹Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

²Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

д заасан заалт, санхүүгийн тайлангийн аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт хүргүүлсэн.

3. Албан хаагчид анхан шатны баримтгүй томилолтын зардалд 1,370.0, ахмадын баяр, замчдын баяр тэмдэглэн өнгөрүүлэх зардалд 3,736.8, сургалтын зардалд 2,902.0 шатны баримтгүй зарцуулсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1, 13.6, 13.7, 20.1.1, 20.1.2, 20.1.4, 20.2.4 дэх заалтыг тус тус хэрэгжүүлэн ажиллаагүй, санхүүгийн тайлангийн аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт хүргүүлсэн.

4. Албан хаагчдыг шагнаж урамшуулахдаа байгууллагын дотоод журамд заасан мөнгөн дүнгээс илүү шагнал олгосон нь Төсвийн тухай хуулийн 16.5.5, байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын 6.4, 6.5 дахь заалттай нийцээгүй, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт хүргүүлсэн.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Нийт орлого

Илрүүлэлт: Тайлант онд НӨАТ ногдох орлогыг 17.7 сая төгрөгөөр дутуу тайлагнасан нь санхүүгийн тайлангийн аудитын үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 7.1, 16.1, 16.1.1 -д заасан заалтуудыг бүрэн хэрэгжүүлэн ажиллах

2. Нийт зардал

Илрүүлэлт: Зам тээврийн яамтай байгуулсан гэрээнд заасан заалтын дагуу туслан гүйцэтгэгчээр 142.5 сая төгрөгийн ажил гүйцэтгүүлэхдээ зам тээрийн яамнаас зөвшөөрөл авч гүйцэтгүүлээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Улсын чанартай авто зам, замын байгууламжид 2024 онд арчлалт, засварын ажил гүйцэтгэх гэрээнд заасан заалтыг бүрэн хэрэгжүүлэн ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Зургаа.Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

сая төгрөгөөр/												
Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
“БУЛГАН-АЗЗА “ ТӨХК	1	3.3	1	3.3			1	3.3				
Дүн	1	3.3	1	3.3	-	-	1	3.3	-	-	-	

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/								
Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил /төрийн хэмнэлтийн тухай хууль/								
БУЛГАН-АЗЗА “ ТӨХК	1	1.00	1	1.00			0	0
Нийт дүн	1	1.00	1	1.00			0	0

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	/сая төгрөгөөр/											
	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
БУЛГАН-АЗЗА “ ТӨХК	5	171.1	3.0	10.8	0.0	0.0	2	160.3				
Дүн	5	171.1	3.0	10.8	0.0	0.0	2	160.3	0	0	0	0

